



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/643

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаал, 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх хүсэлт гаргасан 3 иргэний нийт 0.0673 га (673 м²) газрыг хавсралтаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.


2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
12 дугаар сарын 5-ны өдрийн
А/643 дүгээр захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭДИЙН ЖАГСАЛТ

№	Эрх шилжүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн овог, нэр, регистр	Эрх шилжүүлэн авч байгаа иргэн, аж ахуйн нэгжийн овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын зориулалт	Газрын байршил, хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар эзэмшүүлэх хугацаа	Хүчингүй болгож буй захирамжийн дугаар	Тайлбар
1	Бөхчууд овгийн Түмэн-Өлзий Эрдэнэ (РУ7511416)	Тугч овгийн Бямбабаатар Нарангараг (РЭ91062009)	6712016617	Гэр, орон сууцны хашааны газар	7-р баг 33-12а тоот	280	1	Аймгийн Засаг даргын 2017.09.05-ны өдрийн А/578 дугаар захирамжийн хавсралтын 10 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
2	Чонод овгийн Баатар Оюун-Эрдэнэ (РЭ69050609)	Бөхчууд овгийн Түмэн-Өлзий Эрдэнэ (РУ7511416)	6712015788	Гэр, орон сууцны хашааны газар	7-р баг 33-12в тоот	248	11	Аймгийн Засаг даргын 2020.03.11-ний өдрийн А/162 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
3	Бөхчууд овгийн Түмэн-Өлзий Эрдэнэ (РУ7511416)	Тугч овгийн Бямбабаатар Нарангараг (РЭ91062009)	6712015829	Үйлдвэрлэлийн барилга, байгууламж	7-р баг 33-13г тоот	145	10	Аймгийн Засаг даргын 2020.04.15-ны өдрийн А/226 дугаар захирамжийн хавсралтын 10 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр

Handwritten signature

Нийт газрын хэмжээ: 673м²

000